



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/329

Арвайхээр

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2.г, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны “Аймгийн 2011 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 11/01 дүгээр тогтоолоор шийдвэрлэгдсэн эсгүүр гаргадаг цаасан уутны тоног төхөөрөмжийг шилжүүлэн хүлээн авч, аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэсүгэй.

2. Тоног төхөөрөмж шилжүүлэн, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал –Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд: Ж.Оюунчимэг –аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын Халамжийн хэлтсийн дарга
А.Баяндүүрэн - Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн
газрын мэргэжилтэн
Б.Лхагвасүрэн –Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны
Өвөрхангай аймаг дахь салбарын тэргүүн
Г.Дуламжав – Иргэний төлөөлөл (зөвшилцсөнөөр)

3. Хөрөнгийг акт үйлдэн хүлээн авч балансад бүртгэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100711